



**МОНГОЛ УЛСЫН
БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН
ЯАМ**

15170 Улаанбаатар хот,
Чингэлтэй дүүрэг, Барилгачдын талбай 3,
Утас: 7600 3333, 31 06 12, Факс: (976-11) 32 29 04,
И-мэйл: info@mcud.gov.mn, Вэбсайт: www.mcud.gov.mn

2019.03.28 № 03/1062

танай _____-ны № _____-т

“БАРИЛГЫН ХӨГЖЛИЙН ТӨВ”
ТӨААТУГ, ГАЗАР ЗОХИОН
БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ,
ЗУРАГ ЗҮЙН ГАЗАРТ

Төлөвлөгөө хүргүүлэх тухай

Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолоор 2019 оныг “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил” болгон зарлаж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний баталсны хүрээнд Барилга, хот байгуулалтын яам, түүний харьяа байгууллагуудын хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хавсралтаар хүргүүлж байна.

Тус төлөвлөгөөнд туссан арга хэмжээг хэрэгжүүлэн тайланг хагас, бүтэн жилээр гарган, улирлын дараа сарын эхний 7 хоногт багтаан ирүүлж байхыг хүсье.

Хавсралт ¹⁵ хуудастай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН



БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/45


Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, Монгол Улсын Яамны эрхзүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.8 дахь хэсэг, 9.6.2 дахь заалтыг тус тус үндэслэн “2019 оныг иргэн төвтэй төрийн үйлчилгээний жил болгох тухай” Засгийн газрын 2019 оны 23 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хэрэгжүүлэх зорилгоор ТУШААХ нь:


1. “Иргэн төвтэй төрийн үйлчилгээний жилийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.
2. Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлж, биелэлтийг хагас, бүтэн жилээр гаргаж ажиллахыг яамны холбогдох газар хэлтэс, харьяа байгууллагуудын дарга нарт үүрэг болгосугай.
3. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний биелэлтийг хагас, бүтэн жилээр нэгтгэн, хяналт-шинжилгээ, үнэлгээ, хийж, дүгнэлт гаргаж, танилцуулахыг Хяналт, шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /Н.Нарантуяа/-т үүрэг болгосугай.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



С.МАГНАЙСҮРЭН

Төрийн нарийн бичгийн даргын
2019 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн
А/45 дугаар тушаалын хавсралт



**ЗАСГИЙН ГАЗРЫН 2019 ОНЫ 23 ДУГААР ТОГТООЛООР БАТЛАГДСАН
“ИРГЭН ТӨВТЭЙ ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖИЛ”-ИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

Зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ <i>/Ямар бодлогын баримт бичигт тусгагдсан/</i>	д/д	Арга хэмжээний нарийвчилсан төлөвлөгөө	Хэрэгжүүлэх хугацаа	Суурь түвшин буюу өмнөх оны үзүүлэлт	Тухайн жилийн хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хэрэгжүүлэх байгууллага, газар
1.1. Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийг ашиглан иргэн төвтэй “ухаалаг үйлчилгээ”-г хөгжүүлэх	1.1.1. Төрийн үйлчилгээнд тоон гарын үсгийг үе шаттай нэвтрүүлж, Төрийн цахим мэдээлэл солилцооны системд төрийн байгууллагуудыг холбох үйл ажиллагааг эрчимжүүлж, цахим хэлбэрээр үзүүлэх төрийн үйлчилгээний тоог нэмэгдүүлэх; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.17/</i>	1.	Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг ашиглагч аймаг, нийслэл, дүүргийн Газрын албаны мэргэжилтэн, сумын Газрын даамлуудад тоон гарын үсгийг ашиглуулж, програм хангамжийн хандалт болон үйл ажиллагааг баталгаажуулах ажлыг зохион байгуулах, тоон гарын үсгийг ашиглан бусад байгууллагуудтай мэдээлэл солилцох боломжийг бүрдүүлнэ.	III улирал	Иргэнийг цахим орчинд таниж, нотолж чадах баталгаа бүхий тоон гарын үсэгт нэвтэрсэн	Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг ашиглагч нар тоон гарын үсгийг ашигладаг болсон байна	ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс
	1.1.2. Барилгын салбарын хуулийн этгээдийн нэгдсэн бүртгэл хөтлөх, шинэчлэх, мэдээллийг мэдээллийн санд байршуулах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах <i>/Засгийн газрын 2018 оны 51 дүгээр тогтоолоор гүйцэтгэж</i>	2.	Барилгын салбарын мэдээллийн нэгдсэн сангийн барилга угсралт, зураг төсөл, өргөх байгууламж, түүний угсралт	Жилдээ	Төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл нь	Мэдээлэл тогтмол, үнэн зөв байх, олон нийтэд нээлттэй, хүртээмжтэй, нэгдсэн тайлан	БХТ Барилга, барилгын материалын

**байгаа Барилгын тухай
хуулийн 34.1.7/**

		засварын үйлчилгээ үзүүлэх, барилгын материал үйлдвэрлэгч аж ахуйн нэгж байгууллага, инженер техникийн ажилтны мэдээллийг мэдээллийн сангийн программд бүртгэж, мэдээллийн санг тогтмол шинэчилж төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийг мэдээллийн ил тод байдлын хуулийн хүрээнд мэдээ, мэдээллээр хангах;		нээлттэй болсон байна.	мэдээ гарсан байна.	Үйлдвэрлэлийн хэлтэс
3	Жилдээ	Дижитал шилжилтийн хүрээнд цахим хэлбэрээр албан бичиг солилцооны нэгдсэн системийг ашиглалтад оруулах;		Засгийн газар хоорондын удирдлагын цогц програм хангамж болох Able програмыг нэвтрүүлсэн байна.	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн дэвшлийн хүрээнд цахим хэлбэрээр албан бичиг солилцооны нэгдсэн системийг ашиглалтад оруулсан байна.	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс
4	Эхний хагас жилд	Тоон гарын үсгийг яам болон харьяа байгууллагууд хооронд мөн аймаг, нийслэлийн тамгын газар хооронд		Тоон газрын үсгийн гэрчилгээний эрхүүд авагдсан. Оффисын	Байгууллага хооронд ABLE системээр тоон гарын үсэг	БХБЯ Төрийн захиргааны удирдлагын газар

		ABLE системийг ашиглан нэвтрүүлэх		програмуудад ашиглах боломжтой байна.	нэвтэрсэн байна.	Харьяа байгууллагууд
1.2.Иргэдийн хэрэгцээнд суурилсан төрийн үйлчилгээний стандартын тогтолцоог хөгжүүлэх	1.2.2. төрөөс үзүүлдэг үйлчилгээний чанарыг нэмэгдүүлэх, төрийн үйлчилгээний байгууллага бүр тоо хэмжээ, цаг хугацаа, чанар, өртөг гэсэн үзүүлэлтээр үйлчилгээний стандарт тогтоож хэрэгжүүлэх; <i>/Гурван тулгуурт хөгжлийн бодлого-3.5.2.8/</i>	5. Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг “ХУР” системд холбон иргэн, аж ахуйн нэгжийн бүртгэлийг баталгаажсан эх үүсвэрээс авах, иргэний давтагдашгүй мэдээлэл болох хурууны хэзгээр бүртгэж, баталгаажуулах	III улирал	Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг “ХУР” системд холбох ажил хийгдэж байна	Газрын кадастрын мэдээллийн сангийн Лэнд менежер програм хангамжийг “ХУР” системд холбож төрийн үйлчилгээний чанар сайжирсан байна	ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс, Орон зайн мэдээлэл, технологийн хэлтэс
		6. Түрээсийн орон сууцны мэдээллийн санг ашиглалтад оруулах	12 сард	Мэдээллийн сан хийж байна.	ХУР системд холбогдсон байна.	БХБЯ Нийтийн аж ахуй бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
		7. Барилга, хот байгуулалтын салбарын тоон статистик мэдээллийг хур системд холбох	Жилдээ	Мэдээллийн сангийн судалгаа хийгдэж байна.	ХУР системд холбогдсон байна.	БХБЯ Бодлого төлөвлөлтийн газар
		8. Тусгай зөвшөөрөлтэй ААН-ийн мэдээллийг ХУР системээс авах, холболт хийх	Жилдээ	Тусгай зөвшөөрлийн мэдээллийн систем цахимжсан.	ХУР системд холбогдсон байна.	БХБЯ Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг

						зохицуулах газар ТББ-ууд	
	1.3.1. байгууллага бүр үйлчилгээний менежментийг сайжруулах чиглэлээр хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.5/</i>	9.	Иргэдэд хүргэдэг үйлчилгээ чанартай, хүртээмжтэй, хүнд сурталгүй шуурхай байгаа эсэх талаар иргэдийн хандлагыг тандан судалж, түүнд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр цаашид хэрэгжүүлэх бодлого, үйл ажиллагааг тодорхойлох	2-р улиралд	Хэрэглэгчийн сэтгэл ханамжийн судалгаа, үнэлгээ гаргуулсан байна.	Хэрэгжилтийг хангаж ажилласан байна.	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс
1.3.Иргэн төвтэй төрийн үйлчилгээний менежментийг сайжруулах хөтөлбөрийг салбар бүрд хэрэгжүүлэх	1.3.2. үйлчлүүлэгчтэй харилцах нэгжийг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан бэхжүүлж, үйлчилгээний ажилтан, менежерийг чадавхжуулах, холбогдох сургалтад хамруулах; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.5/</i>	10.	ИТА-нууд болон нийт ажилтан албан хаагчид, үйлчилгээний ажилтан болон менежерийг чадавхжуулах сургалтад хамруулах;	Улирал тутам	Мэргэшсэн баг бүрдсэн байна.	Үйлчилгээний менежмент, чанар, хүртээмж дээшилсэн байна.	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс
		11.	Газрын харилцааны салбарын буюу аймаг, нийслэл, дүүргийн Газрын албаны мэргэжилтэн, сумын Газрын даамлуудыг (I)Газрын кадастрын мэдээллийн сан, (II)Газрын бирж, (III)Газрын үнэлгээ гэсэн 3 төрлийн сургалтанд үе шаттайгаар хамруулан чадавхжуулах	III улирал	Газрын кадастр, Газрын бирж, Газрын үнэлгээний чиглэлээр үйлчилгээ үзүүлэх	Газрын кадастрын мэдээллийн санд суурилсан Газрын бирж, Газрын үнэлгээний үйл ажиллагааг эрхлэх чадавхитай болох	ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс

1.5.Төрийн үйлчилгээний төвлөрлийг сааруулж, үйлчлүүлэгчийг хамгаалах тогтолцоог бүрдүүлэх	1.5.2. төрийн үйлчилгээний шимтгэл, төлбөрийн хэмжээг бууруулах; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-1.18/</i>	12.	Төрийн үйлчилгээний шимтгэл төлбөртэй холбоотой асуудлаар холбогдох байгууллагуудад хүсэлт уламжлана.	IY улирал	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах	БХБЯ
	1.5.4. хөрөнгө оруулагчдад төрийн үйлчилгээ үзүүлэх зорилго бүхий “Нэг цэгийн үйлчилгээний төв”-ийн үйл ажиллааг эхлүүлж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиглэлээр өргөдөл, гомдлын цахим системийг ашиглалтад оруулах; <i>/Турван тулгуурт хөгжлийн бодлого-3.9.3.11/</i>	13.	Магадлалын үйл ажиллагааны “Нэг цэгийн үйлчилгээ” дэх төвлөрлийг нэмэгдүүлэх, тухайн зураг төслийг хянах чиглэлийн экспертүүд, түүний зохиогч, төсөвчин нарын харилцан уялдааг дээшлүүлэх,	I-IV улиралд	Нэг цэгийн үйлчилгээ жигдэрч, цахим системийг нэвтрүүлж, хэвийн ажиллагааг хангасан байна.	Барилга байгууламжийн зураг төсөлд магадлал хийх үйл ажиллагаа нь хууль тогтоомжийн дагуу нэг цэгийн үйлчилгээг илүү шуурхай болгон, зураг төслийн чанарыг сайжруулсан байна.	БХТ Барилга байгууламжийн зураг төслийн магадлалын хэлтэс
	1.5.6. чанаргүй үйлчилгээ болон үйлчилгээг стандартын дагуу авч чадаагүйгээс үүссэн хохирлыг барагдуулах эрх зүйн орчинг бүрдүүлэх. (нөхөн төлбөр, төлбөр буцаан олголт) <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-2.12/</i>	14.	“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хүрээнд Барилга, хот байгуулалтын яамны дэргэдэх “хэрэглэгчийн эрхийг хамгаалах орон тооны бус дэд зөвлөл”-ийн хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан батлуулж хэрэгжүүлэх	II улирал	Дэд зөвлөл байгуулагдсан.	“Хэрэглэгчийн эрхийг хамгаалах үндэсний хөтөлбөр”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна	БХБЯ Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар
2.1.Шийдвэр гаргах үйл явцыг	2.1.1. бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагаанд	15.	“Аймаг, нийслэлийн газрын кадастрын	III улирал	“Аймаг, нийслэлийн	Газрын кадастрын	ГЗБГЗЗГ

<p>ил тод болгож, иргэдийн оролцоог хангаж</p>	<p>иргэдийн оролцоог хангаж, мэдээлэл ил тод, нээлттэй, хүртээмжтэй байх нөхцөлийг бүрдүүлэх; <i>/Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-3.9.6/</i></p>	<p>мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” ажлын хүрээнд Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санг бий болгож байрлалд суурилсан баталгаажсан мэдээллээр иргэд, олон нийтэд үйлчлэх. Мөн Egazar.gov.mn цахим хаяг бүхий порталаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх, газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломжийг бүрдүүлэх</p>		<p>газрын кадастрын мэдээллийн санг өндөр, тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлж засварлан, улсын кадастрын нэгдсэн мэдээллийн системд холбож, үйлчилгээнд нэвтрүүлэх” ажил үргэлжилж байна</p>	<p>мэдээллийн нэгдсэн санг байгуулж иргэд, олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим хаяг бүхий портал үйл ажиллагаанд бүрэн орсон байна</p>	<p>Кадастрын хэлтэс</p>
		<p>16. “Газрын цахим биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж, оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангах эдийн засгийг</p>	<p>III улирал</p>	<p>“Газрын цахим биржийн эрх зүйн орчныг бүрдүүлэх, газрын дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалт, түрээс, барьцааг цахимаар зохион байгуулж,</p>	<p>Газрын цахим биржийг үйл ажиллагаанд бүрэн оруулж газрыг эдийн засгийн эргэлтэнд оруулах бодит боломж бүрдсэн байна.</p>	<p>ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс</p>

		<p>“эрчимжүүлэх” ажлын хүрээнд Газрын цахим биржийн үйл ажиллагааг сайжруулан хэрэглээнд нэвтрүүлж газрын эрхийн дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах, иргэд газраа эдийн засгийн эргэлтэнд оруулж газрын үр шимийг хүртэх бодит боломжийг бий болгох</p>		<p>оролцогч талуудыг эрх тэгш байдлаар хангах эдийн засгийг “эрчимжүүлэх” ажил үргэлжилж байна</p>		
		<p>“Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох” ажлын хүрээнд газрын бодит үнэ цэнийг тодорхойлж нээлттэй болгох, газрын төлбөр, татварын цахим системийг хөгжүүлэх</p>	III улирал	<p>“Улсын хэмжээнд газрын бодит үнэ цэнийг олон улсын жишгийн дагуу зах зээлийн зарчимд үндэслэн тогтоож, газрын суурь үнийг шинэчилж, иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болгох” ажил үргэлжилж байна</p>	<p>Газрын бодит үнэ цэнийг тодорхойлж нээлттэй болгох, газрын төлбөр, татварын цахим системийг хөгжүүлсэн байна</p>	<p>ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс</p>
<p>2.1.2. зөвлөлдөх ардчиллын санал асуулгыг нэвтрүүлэн иргэдийг тэнцвэртэй, үнэн зөв мэдээллээр ханган, шийдвэр гаргах түвшний</p>	17.	<p>Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж баталгаажсан мэдээллийг Egazar.gov.mn цахим</p>	III улирал	<p>Иргэд, олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим хаяг бүхий порталын</p>	<p>Иргэд, олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим хаяг бүхий портал</p>	<p>ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс</p>

	иргэдийн оролцоог нэмэгдүүлэх; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.4/</i>	хаяг бүхий порталаар дамжуулан иргэд, олон нийтэд хүргэх, газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээ болон өргөдөл, хүсэлтийг үйлчилгээг цаг хугацаа, орон зайнаас үл хамааран авах боломжийг бүрдүүлж, үйл ажилаагааг зохион байгуулах		хөгжүүлэлт хийгдэж байна	үйл ажиллагаанд бүрэн орсон байна	
2.2.Төсөв, хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг нэмэгдүүлэх	2.2.1. шилэн дансны мэдээллийг хугацаанд нь тогтмол мэдээлэх, хяналт, хариуцлагыг сайжруулах; <i>/Шилэн дансны тухай хууль/</i>	18. Шилэн дансны цахим бүртгэл хөтөлж, “Шилэн дансны журам”-ыг хэрэгжүүлэн ажиллаж, холбогдох тайлан, мэдээг гаргах;	Жилдээ	Мэдээлэл нь үнэн зөв, цаг хугацаандаа, бүрэн гүйцэд оруулж хэвшсэн байх.	Зөрчил, дутагдал багассан байна	БХТ Захиргаа удирдлагын хэлтэс. Санхүү, төсөл хөтөлбөрийн хэлтэс
		19. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө гаргах, төлөвлөгдсөн ажлын зарыг шилэн дансны цахим хуудсанд байршуулах;	Жилдээ	Мэдээлэл нь үнэн зөв, цаг хугацаандаа, бүрэн гүйцэд оруулж хэвшсэн байх.	Мэдээлэл ил тод нээлттэй болсон байна	
2.3.Байгууллагын ил тод, нээлттэй байдлыг нэмэгдүүлэх	2.3.1. төрийн үйлчилгээг иргэнд хүргэх чиг үүрэг бүхий байгууллага өөрийн үйл ажиллагаандаа мөрдөж байгаа дүрэм, журам, үйлчилгээний ажилтны чиг үүрэг, эрх хэмжээ, үйлчилгээ үзүүлэх хугацаа, бүрдүүлэх шаардлагатай материал зэрэг мэдээллийг нээлттэй хүргэж байх;	20. Зураг төслийн магадлал хийлгэх, барилгын материалд сорил шинжилгээ хийлгэх, барилгын материал баталгаажуулалт, батлагдсан норм, дүрэм, захиалагчийн хяналтын ажлын явцыг байгууллагын цахим хуудас болон	Жилдээ	Үйлчилгээ авахад шаардагдах бичиг баримтын жагсаалтыг цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулж,	Баримтлах бодлого болон хуулийн төслийг боловсруулах Үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын жагсаалтыг багтаасан хууль,	БХБЯ Барилгаа, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар БХТ

	<p><i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.2.7/</i></p>	<p>мэдээллийн самбарт байршуулах. Мөрdej байгаа хууль тогтоомж, дүрэм журамд нэмэлт өөрчлөлт орох болон шинэчилэгдэн гарсан тохиолдолд цахим хуудсаар тогтмол шинэчилэх Салбарын хэмжээнд хэрэгжиж буй үйл ажиллагаа болон төвийн үйл ажиллагааг олон нийтэд сурталчилах зорилгоор “Барилгын мэдээлэл” сэтгүүлийг сар бүр эрхлэн гаргах</p>		<p>мэдээлэл тухай бүр шинэчилэгдсэн байна.</p>	<p>тогтоомж, дүрэм, журмын эмхэтгэлийг гаргаж олон нийтийн хүртээл болгосон байна.</p>
	<p>2.3.2. иргэн, хуулийн этгээдэд хэрэгцээтэй, тэдэнд хамаарах шийдвэрийг цахим хуудас болон бусад хэлбэрээр нийтэд мэдээлж хэвших; <i>/Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2.3.8/</i></p>	<p>22. Барилгын салбарын мэдээллийн нэгдсэн систем болох Зураг төслийн иж бүрдэл илгээх мэдээллийн сан, Захиалагчийн хяналт хэрэгжүүлэх мэдээллийн бааз, байгууллагын цахим хуудас болох Barilga.gov.mn хаягаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээллийн аюулгүй байдлыг хангаж, түргэн шуурхай, тогтмол, мэдээлэх;</p>	<p>Жилдээ</p>	<p>Төвөөс үзүүлж буй үйлчилгээний чанар сайжирсан байна.</p>	<p>Мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэж хэвшсэн байна</p>
		<p>23. Газрын кадастр, газрын бирж, газрын үнэлгээтэй холбоотой мэдээ,</p>	<p>III улирал</p>	<p>Газрын кадастр, Газрын бирж, Газрын</p>	<p>Газрын кадастр, Газрын бирж,</p>

БХТ

ГЗБГЗЗГ

	мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд мэдээллэх		үнэлгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд тухай бүр хүргэдэг	Газрын үнэлгээтэй холбоотой мэдээ, мэдээллийг байгууллагын цахим хуудсаар дамжуулан иргэд олон нийтэд тогтмол хүргэж хэвшсэн байна	Кадастрын хэлтэс
2.3.3. иргэнээс гарах үйл ажиллагааны зардал, төрийн үйлчилгээ авах цаг хугацааг бууруулах зорилгоор шат дамжлагыг цөөлөх, үйл ажиллагааг оновчтой болгоход чиглэсэн дүрэм, журмыг хянан үзэж өөрчлөх, хүчингүй болгох арга хэмжээ авах; <i>/Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2.3.8/</i>	24.		II улирал	-	Судалгаа хийж, дүрэм, журмын холбогдох заалтыг хүчингүй болгох
2.3.4. байгууллагын шийдвэр гаргах үйл ажиллагаа нь тухайн байгууллагын ажилтнуудад нээлттэй байх, шийдвэрийн үндэслэлийн талаарх мэдээллийг иргэн, хуулийн этгээдэд нээлттэй болгох.	25.		IV улирал	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах

	<i>Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-3.9.4/</i>						
2.4.Мэдээлэл хүргэх оновчтой тогтолцоог бий болгох	2.4.2. төрийн байгууллагуудаас иргэн, хуулийн этгээдэд цахим хэлбэрээр үйлчилгээ үзүүлэх мэдээллийн системд танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системийг холбох; <i>Төрөөс мэдээлэл, харилцаа холбооны хөгжлийн талаар баримтлах бодлого-2.3.8/</i>	26.	Газрын кадастрын мэдээллийн нэгдсэн санд бүртгэгдэж баталгаажсан мэдээллийг иргэд, олон нийтэд хүргэх Egazar.gov.mn цахим хаяг бүхий порталд хандах хэрэглэгчийг танилт нэвтрэлтийн нэгдсэн ДАН системд холбох	III улирал	Иргэд, олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим хаяг бүхий порталын хөгжүүлэлт хийгдэж байна	Иргэд, олон нийтэд зориулсан Egazar.gov.mn цахим хаяг бүхий портал үйл ажиллагаанд бүрэн орсон байна	ГЗБГЗЗГ Кадастрын хэлтэс
2.5.Тусгай зөвшөөрөл, гэрээний ил тод байдлыг хангах	2.5.3. барилгын тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагааг цахим хэлбэрээр үзүүлэх. <i>Нээлттэй засгийн түншлэл-11/</i>	27.		IV улирал	-	Тусгай зөвшөөрөл олгох үйл ажиллагаа сайжирсан байна	БХБЯ Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар ТББ-ууд
3.2.Чиг үүргийн дахин хуваарилалтыг хийж, бүтэц, зохион байгуулалтыг оновчтой болгох	3.2.1. Төвлөрлийг сааруулах, төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар,	28.	Байгууллагын бүрэлдэхүүн, удирдлагын түвшний уялдаа, үйл ажиллагааны үр дүнг ил тод, нээлттэй байлгах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах, байгууллагын үйл ажиллагааны чанар,	Жилдээ	Байгууллагын төсөв, санхүүгийн нөөцийг зөв хувиарлах түүний зарцуулалт, зардлын хэмнэлт гаргаж, орлого, зарлагын тооцоонд	Төрийн айгууллагын чиг үүрэг, хүлээх хариуцлага годорхой болсон байна	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс

	хүртээмжийг сайжруулах зорилгоор төрийн захиргааны болон нутгийн удирдлагын байгууллагын чиг үүргийн иж бүрэн шинжилгээ хийж, чиг үүргийг дахин хуваарилах; <i>Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.5.1/</i>		хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх, шуурхай байдлыг хангахад чиглэгдсэн хяналт, шинжилгээ үнэлгээг хийх ажлыг зохион байгуулах		тогтмол хяналттай болно		
4.1. Гүйцэтгэлийн үнэлгээгээр хувь хүний өрсөлдөх чадварыг хөхиүлэн дэмжих	4.1.1. үр дүнд суурилсан удирдлагын хяналт, шинжилгээ, үнэлгээний системийг нэвтрүүлэх; <i>Нээлттэй засгийн туншилал-12/</i>	29	Барилгын хөгжлийн төвийн үйл ажиллагаа, цаашдын зорилт, хэлтэс хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах талаар чиг үүргийн давхардал хийдлийг арилгах мөн дотоод хяналтыг сайжруулж, хяналт, шинжилгээ үнэлгээний журам боловсруулж хэрэгжүүлэн ажиллах	Жилдээ	Тус төвийн үйл ажиллагаа, цаашдын зорилт, хэлтэс хоорондын ажлын уялдаа холбоог сайжруулах, жилтнуудын идэвх аанаачилга, бүтээлч байдал дээшилсэн байна.	Бодлого төлөвлөлт, төсөвлөлт, үйл ажиллагааны үйцэтгэл, үр дүн, үр нөлөө нэмэгдсэн байна	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс
4.2. Гүйцэтгэлийн үнэлгээг сайжруулж, олон тулгуурт хяналтын тогтолцоог хөгжүүлэх	4.2.1. төрийн байгууллагын үйл ажиллагааг бус үр дүнг үнэлдэг үнэлгээний тогтолцоог хөгжүүлэх; (иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэвтрүүлж төрийн бодлогын үр дүн, төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг хараат бусаар үнэлж, дүгнэн зөвлөмжийн дагуу хариу арга хэмжээ авч ажиллах соёлыг хэвшүүлэх)	30	Иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг нэвтрүүлэх	ГҮ улирал	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах	БХБЯ Төрийн захиргааны удирдлагын газар ГХГЗЗГ БХТ

	<i>/Нээлттэй засгийн түншилэл-7/</i>							
5.1.Төрийн албаны хүний нөөцийн төлөвлөлтийг хөгжүүлж, сургалт хөгжлийн бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх	5.1.1. иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг тууштай хэрэгжүүлэх; <i>/Төрийн албаны тухай хууль/</i>	31	иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулахдаа хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлах зарчмыг хэрэгжүүлэх	ҮУ улирал	-	Хэрэгжилтийг хангаж ажиллах	БХБЯ Төрийн захиргааны удирдлын газар	
	5.1.3. төрийн албан хаагч тогтвортой ажиллах, төрийн алба хаших шалгуур нь зөвхөн мэргэшлийн болон уг албыг гүйцэтгэх мэдлэг чадвар, мэргэжлийн ёс зүйгээр тодорхойлогддог байх нөхцөлийг бүрэн хангах; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.11/</i>	32	Албан хаагч нь эрхэлсэн ажил, албан үүргээ амжилттай гүйцэтгэх, мэдлэг, олж авах, мэдээлэл солилцох онол, арга зүйд суралцах, ур чадвар эзэмшүүлэх	Албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах, нөхцөл бүрдүүлэх	Жилдээ	Шинэ мэдлэг, туршлага бий болгосноор үйл ажиллагааны өндөр чадавхитай байгууллагыг төлөвшүүлж, иргэдэд чанар сайтай төрийн үйлчилгээг үзүүлнэ	Хэрэгжилтийг хангаж ажиллах	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс
		34	Албан хаагчдыг сургах замаар тус байгууллагыг хөгжүүлэх, салбарын бодлогын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд дэмжлэг үзүүлэх					
5.2.Цалин хөлс, урамшуулал,	5.2.4. төрийн албан хаагчийн орон сууцны хөтөлбөрийг баталж, орон сууцаар	35	2019 онд хэрэгжүүлэх "Албан хаагчийн ажиллах нөхцөл,	Жилдээ	Албан хаагчийн нийгмийн баталгааг хангах	Холбогдох хөтөлбөр, журам	БХТ	

нийгмийн баталгаа	хангагдах нөхцөлийг бүрдүүлэх; <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.12/</i>	нийгмийн баталгааг хангах” батлагдсан төлөвлөгөөний дагуу Ажилтнуудад нэгдсэн орон сууц бариулах асуудлаар холбогдох газруудад санал хүргүүлж, нөхцөл боломжийг судалж, хамтран ажиллах		бодлогыг хэрэгжүүлснээр байгууллагын хүний нөөцийн чадамж дээшилж, ажлын дадлага, туршлагатай мэргэшсэн ажилтнаас бүрдэж, тэдгээрийг албан тушаалын чиг үүргээ аливаа нөлөөллөөс ангид хэрэгжүүлэх нөхцөл хангагдана.	батлагдсан байна	Захиргаа, удирдлагын хэлтэс
5.3.Ажлын байрны шинжилгээ, үнэлгээ	5.3.1. ажлын байрны шинжилгээг хийж, тухайн ажлын байранд тавигдах шалгуурыг тодорхой тогтоох, ажил үүргийн давхардал, хийдлийг арилгах, цалин хөлсний системийг боловсронгуй болгох, ажилтнуудын сургалтын хэрэгцээг тодорхойлох, ажилтнуудын ачааллыг тэнцвэржүүлэх арга хэмжээ авах. <i>/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө-5.1.5/</i>	36 Ажлын байрны тодорхойлолтыг тухайн байгууллагын хуулиар хүлээсэн чиг үүрэгтэй уялдуулан хуульд заасны дагуу дахин боловсруулж, ажилтнуудын үр дүнгийн болон хөдөлмөрийн гэрээг хагас, бүтэн жилээр дүгнэж, урамшуулах, хариуцлага тооцож ажиллах	Жилдээ	Байгууллагын албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолт нь тухайн байгууллага нэгжүүдийн зорилт, чиг үүрэгтэй уялдсан байна.	Хэрэгжилтийг хангаж ажилласан байна	БХТ Захиргаа, удирдлагын хэлтэс